

УДК 930.85+398.8

ӨВӨР МОНГОЛЫН АЛДАРТ ЯРУУ НАЙРАГЧ АРТАЙН УРАН БҮТЭЭЛ ДЭХ ЯРУУ СЭТГЭМЖ

Тогтоомж

БНХАУ-ын Өвөр Монголын Өөртөө Засах орны яруу найрагч, Монгол Улсын Их Сургуулийн Улаанбаатар сургуулийн докторант

E-mail: 1300579540@qq.com

Хураангуй

Шүлэг бол утга зохиолын эрдэнийн суварга дээрх гэрэлт сувд билээ. Эх хэлээрээ шүлэг бичдэг мөртлөө уншигчдынхаа хайр талархлыг хүртэнэ гэж ёстой ариун дээд яруу алдар байх ёстой. Артай хэдэн арван жил шүлэг бичээд эх хэлнийхээ зохион бүтээх өрнөл хөгжлийг ахиулсан төдийгүй монгол үндэстний утга зохиолын эрдэнэсийн санг баялагжуулж, шалгарсан уран бүтээлч хийгээд утга зохиолын үйлст үзүүлсэн гарамгай хувь нэмрийг үе олноос хүртсэн сайн сайхан үнэлэлт сайшаалаараа шинэ Дундад улсын анхны үеийн шүлэгчдийн төлөөлөгч Н. Сайцогтын дараа хоёрдугаар үеийн монгол үндэстний шүлэгчдийн төлөөлөгч хэмээн үнэлэгдсэн билээ. Бид яруу найргийг уншсанаар дүрслэл бэлгэдлийн болоод хэлэхүй сэтгэхүйн, хөг аялгууны болоод утга санааны гэхчлэн олон талт цэнгэлийг эдэлдэг. Энэ нь зөвхөн яруу найрагчид хэмээх сэрэл мэдэрхүйн торгон мэдрэмжтэй хүмүүсийн утга төгөлдөр, уянга тунгалаг хэлээр бусдад хүртээх баяр, жаргал билээ. Бусдын нүдэнд бараан үүл хургасан усан бороо атал Д.Нямсүрэнгийн нүдэнд “цайран цайран...” орсон бороо. Тэрчлэн О. Дашбалбар гуай “Яруу найрагч гэдэг бол монголын хэмжээнд, дэлхийн хэмжээнд сэтгэж байдаг ард түмнийхээ дуу хоолой, үндэстнийхээ бэлгэ тэмдэг болж байдаг хүмүүс” гэж нэгэнтэй хэлсэн байдаг тийм ч мөн чанар яруу найрагчдын зүрхэнд байдаг байх. Артай бол үндэстний хэмжээний яруу найрагч гэдгийг түүний шүлгүүдэд хийсэн задлал батлан харуулж байна.

Түлхүүр үг

Яруу найраг, Артай, үндэстний сэтгэлгээ.

UDC 930.85+398.8

THE ISSUE OF ARTISTIC IDEA IN POETRY OF ARTAY, THE FAMOUS POET OF INNER MONGOLIA

Togtomzh

PhD student of the National University of Mongolia, Ulaanbaatar, poet of Inner Mongolia Autonomous Region, China.

E-mail: 1300579540@qq.com


Annotation

A poem is a bright pearl on a literary gem. Even if you write poetry in your native language, you should have a sacred and clear glory that you should receive the love and gratitude of your readers. After writing poems for several decades, he not only advanced the development of his native language, but also enriched the literary treasury of the Mongolian nation, and was a distinguished artist and outstanding contribution to the literary work. After Saitsoht, he was recognized as the representative of the Mongolian poets of the second generation. When we read poetry, we enjoy multifaceted pleasures, such as imagery, symbolism, ineffable thinking, melody, and meaning. It is the joy and happiness that only poets can give to others with meaningful and melodious language. In the eyes of others, the rain was a dark cloud, but in the eyes of D. Nyamsuren, the rain was "white...". Also O. Mr. Dashbalbar said to someone that "Poets are people who are the voice of their people who think on a Mongolian and global scale, and are a symbol of their nation". Analysis of his poems proves that Artai is a national poet.

Key words

Poetry, Artai, national mentality.

О Р Ш И Л

Артай 1949 онд Өвөр Монголын Өөртөө Засах орон (ӨМӨЗО)-ы Шилийн гол (монгол бичгээр  – sili-yin γoul, *шили-ийн гоул*; хят. 錫林郭勒 – *xīlínɡuōlè*) аймгийн Дайфүши (太仆寺旗 Tàipúsi Qí) хошууны Гүнбулаг сумын малчны гэрт төржээ. Аав ээжийнхээ хайр халамжаар өсөж торнисон Артай бээр 1956 оны алтан намар Гүнбулаг сумын бага сургуулийн босгыг алхаж, 1962 онд Бээжингийн дунд сургуульд шалгуулан орсон байна. 1964 онд сургуулийнхаа “Улаан залуус” сонины найруулагчаар ажиллаж байхдаа шүлэг бичиж эхэлжээ. 1965 оны намар Шулуун хөх хошуу (正藍旗 Zhènglán Qí)-ны Шандын гол дунд сургуульд шилжин суралцаж, 1968 онд нутагтаа буцаж, ажил хөдөлмөр эрхлэх болов. 1971 онд Ардаас эрхэлсэн сургуулийн орлогч багш болсны хамт Гүнбулаг сумын ажлын чөлөөний Улаанмөчирийн зохион бүтээгчийн ажлыг хавсран “Гүнбулагийн дуулал” хэмээх тосон барын сэтгүүлийг гурван хугацаа эрхлэн найруулжээ. Эдгээр нь бүр түүний “анхны үеийн утга урлагийн үйлдлэг” байсан ажээ.

1. Намтрын хуудас

1973 онд тэр Өвөр Монголын монгол хэл бичгийн тусгай мэргэжлийн сургууль (эдүгээгийн Хөххот үндэсний дээд сургууль)-д шалгуулан ороод 1975 онд сургуулиа төгсөж Шилийнгол аймгийн соёлын товчоонд ажлын хуваарь авчээ. 1978 онд Өвөр Монголын утга урлагийн холбооны “Өнөр цэцэг” сэтгүүлийн хороонд шүлгийн найруулагчаар ажиллаж 1984-1986 онд Өвөр Монголын их сургуулийн зохиол судлах ангид суралцсан. 1985 онд дундад улсын зохиолчдын эвлэлд элсүүлэв. 1988 онд Өвөр Монголын зохиолчдын эвлэлийн дэд тэргүүлэгчээр сонгогдсоны хамт “Өнөр цэцэг”-ийн дэд ерөнхий найруулагч болж 1997 онд Өвөр Монголын зохиолчдын эвлэлийн байнгын дэд тэргүүлэгчээр шилжин ажиллаж, 1999 онд Өвөр Монголын утга урлагийнхан холбооны дэд тэргүүлэгчээр сонгогдон 2004 оны 12 сард Өвөр Монголын утга урлагийнханы холбооны тусгай тушаалт дэд тэргүүлэгч, зохиолчдын эвлэлийн тэргүүлэгчээр сонгогдов. 2005 оны 1-р сард Өвөр Монголын утга урлагийнхны холбооны намын удирдах дугуйлангийн гишүүн болж 2010 онд ажлаасаа амрав.

Дундад улсын эв хамт намын гишүүн, улсын нэгдүгээр дэсийн зохиолч, төрийн явдлын хорооны насан туршийн соёрхолт тусгай мэргэжилтэн, Өвөр Монголын Өөртөө засах орны хөдөлмөрийн жишээч, Өвөр Монголын Өөртөө засах орны намын хороо, засгийн ордноос олгосон “Өөртөө засах орны утга урлагийн үйлст товойм зүтгэл үзүүлсэн алтан медаль” хүртжээ.

Дундад улсын зохиолчдын эвлэлийн зургаа, долоо, найм, есдүгээр хугацааны тэргүүлэгчдийн бүлгэмийн гишүүн, Дундад улсын яруу найргийн нийгэмлэгийн дэд дарга, Дундад улсын цөөн тоот үндэстний зохиолчдын нийгэмлэгийн дэд дарга. Зохиол бүтээл нь урд хожид бүх улсын цөөн тоот үндэстний утга зохиолын бүтээлийн “Ажнай хүлэг” шагнал, Дундад улсын зохиолчдын эвлэлийн “Жувэн Жүн Вен” утга зохиолын шагнал, Өвөр монголын Өөртөө засах орны “Солонго”, “Саран-а”, “Тав нэг инжир”-ийн шагнал хүртжээ.

“Өнөр цэцэг” сэтгүүл ба зохиолчдын эвлэлийн ажлыг хариуцаж байхдаа өдий төдий залуу зохиолчдыг хүмүүжүүлэн, зохиолчдын эгнээг тэлж, манай орны уран зохиолын үйлст чухал хувь нэмрийг үзүүлжээ.

Ууган бүтээл нь 1966 онд нийтлэгдэж, урьд хожид “Бодлын цэнхэр яргуй”, “Сэтгэл урлагийн зай” зэрэг шүлэг найраглал, оршил найруулгын арван дөрвөн ном, “Өвсний навч түүвэр”, “Туульсын цэнхэр тал” (Хятад, Монгол хэвлэл) зэрэг ганцаар буюу хоёул хамтран орчуулж найруулсан зургаан ном хэвлүүлжээ. Зохиол бүтээл нь бага, дундад, их сургуулийн сурах бичигт сонгогдож, Хятад, Англи, Япон, Солонгос, Кирилл үсгээр нийтлэгдсэн буюу хэвлэгдэж, зарим шүлэг нь уншигчдын дунд өргөнөөр тархан дэлгэрчээ. Дундад улсын зохиолчдын төлөөлөгчдийн бүлгэмийг дагуулж урд хожид Монгол улс жич Сингапур, Малайз, Дани улсаар айлчлан улсын дотоод, гадаадын соёлын солилцоог ахиулжээ.

2. Яруу найргийн уран сэтгэмж

“Яруу найрагт зөн билэг нь (интиуц) голлох уу эсвэл ухамсар оюун ухаан нь (энэ тохиолдолд сэдэв боловсруулахыг хэлж байна) голлох уу гэсэн асуулт XX зуунд үеэ өнгөрөөсөн бөгөөд яруу найргийн мөн чанар зохиогчийн субьектив зөн билигт оршино гэдгийг XIX зуун нэгэнт эцэслэн шийдвэрлэсэн юм” (Энхбаяр, 2000: 69-70). Энэ бол монголын яруу найргийн туурвил зүйн хандлага нь чухам дээр дурдсан онцлог зарчмыг “шууд өөрийн санаагаар бичих”, “өөрийн авьяасын ундрэн гарах ёсоор бичих” хэмээн томъёолсонд оршино. Энэ нь яруу найргийн туурвил зүйн хувьд онц чухал ач холбогдол бүхий үзэл санаа юм.

Энэ цаг үеийн содон найрагч Артайн “Сэтгэлийн найман нөхөөс” хэмээх шүлэг “Өнөр цэцэг”-ийн 94 оны хоёрдугаарт нийтлэгджээ. Эсгий туургатны гоо сайхны яруу сэтгэмжийг баяжуулж монгол найргийн инжрийн өнгө гялбааг өөд нь татаж яваа ард түмний хайр хүндэтгэлт яруу найрагчийн энэхүү найман шүлэг нь хэл хэллэгийн нямбайрлаас дүр дүрслэл, санаа төрөгжил болон бүхий л шүлгийн цогцын эсгэмжийн соргог сэвүүн гарчиг бодит нарийн холбооны содон амжилтаараа монгол яруу найргийн хүрээлэнд содхон найман дэлбээг дэлгэжээ.

Аль ч үндэстний бүтээл эх хэлээ гүнзгий эзэмшиж, яруу хөгжимлөг, баян нуугилаг, хошин мэдрэмжтэй, аль ч талаар чадамгай хэрэглэж чаддаг хүн л сая гайхамшигт дүр дүрслэлийн жинхэнэ эзэн болох аз тавилантай байдаг. Шүлгийн санааг төгөлдөржүүлэхэд ч мөн л адил. Артайн “Явъя” гэх шүлэгт:

“Явъя сайхан монгол эхийнхээ

Ямагт ийн хайраа сэмлэн байж

Яалин мөнгөн сарны доор зулсан

Яруу содон бүүвэй өөд явъя” (Артайн шүлгийн түүвэр, 2007: 300) (1993.09.16) гэсэн уяхан сэтгэлгээ бялхарсан бадаг буй. Тус бадагт аялгуу тааруулан дуулсан ч гоо хүртээмж нь хүмүүсийн сэтгэлд шууд нэвтэрч чадах нь илт. Энд “*Сайхан монгол эх*”, “*Ямагт ийн хайраа сэмлэн байж*”, “*Сарны доор зулсан*”, “*Яруу содон бүүвэй*” гэх гоо сайхны хэт ахуй цогцолджээ. Яруу найрагч маань “*Сэмлэн байж*”, “*Зулсан*” гэх үйл үгээр энэхүү ахуйн амьсгал төрөгжилд гол үйлдлийг нь харуулжээ. Яруу найрагчид сэрж олсон хурц саанаагаа өнгө будагтай, дуу чимээтэй, хөдөлгөөнтэй, хөгжмийн эгшигтэйгээр уншигчдадаа дээжлэхэд эн тэргүүнд эзэмших чухалтай гэдгийг энэ нэгэн найргийн бадаг ч гүйцэд тодорхойлж өгсөн юм. Хайр гэдэг олон янз эцэг эх, эх орон, янаг амраг, ах дүү, үр хүүхэд, хүн хүнээ хайрлах гэх мэт. “Энэ яваа нас, эхийн ач, эцэг үрсийн элбэрэл журам бол яруу найрагт уламжилсан сэдэв гэж хэлж болохоор тэр тусмаа монгол яруу найргийн нэн эрхэмлэсэн сэдэв юм” (Мөнх, 1990: 123). Артайн уран бүтээл ч энэ уламжлалаас ангид байсангүй бөгөөд эхийн элбэрэл хайрыг шүлэглэсэн нь цөөнгүй байна.

Нэрт найрагчдын зам мөрийг ажиглан судалж үзэхэд юуны өмнө өөрийн үндэстнийхээ амьдрал оршихуйн чигээс гардан нийгэм хорвоог таньж мэдрэн, урлагийн үзэл санаагаа гүн ухаалаг аясаар хөгжүүлдэг учиртай ажээ. Өөрөөр хэлбэл үндэстний (хэлнийх) нь энэхүү амьдралын орчин тойрон, удамшилт, үе тэмцэн шаардсан гүн ухааных нь охь талст яруу найрагчийнхаа сэрэл сэтгэхүйн үндсэн хэлбэрийг тогтоож өгдөг байна. Энэхүү суурин дээр яруу найрагчаар дэлхий дахины олон охь сонгодог гүн ухаанч урлалын содыг шүүмжлэлтэйгээр сонгон өөрийн эх хэлнийхээ урлалын баян санд зүй зохистойгоор шингээн оруулж хөгжүүлэн сэтгэдэг санжээ.

Артай найрагчийн “Эр зоригийн магтуу”-аас аль олон содон найргууд монгол түмний зүрхэнд мөнх хоногшиж, Өвөр монголын монгол шүлгийн өнгө гялбаа болж байгаагийн нэгэн нууц энэ буюу. Яг ийнхүү хөгжин цэцэглэсэн яруу найрагчийн бүтээл нь ч төрөлх сэтгэхүйнхээ жам горимоос огт гачилгүй байж, яруу найрагчийн бүтээлүүд нь “Хэдий үндэстний болох тусам төдий дэлхий дахиных болдог”. Энд ярьж буй найман шүлгээс ч жинхэнэ монгол найрагч туурвилаа гэдэг нь машид тодорхой.

“Морины совоо тоос шиг

Шингэн униарын цаагуур

Монгол охидын хүзүү шиг

Тэнгэрийн хаяа гийнэ”

Яруу найргийн дүр дүрслэлийн амилах ид шид нь дан ганц шинэ сэвүүн болсондоо л байдаг биш харин өвөрмөц сэвүүн мөртөө нь уншигч болгоны сэтгэлд соргог гоо таашаал, дэгдэрлэг яруу сэрэгдэл олгож чадах чадвахыг бүрэлдүүлсэндээ байдаг. Энэхүү дөрвөн мөрт яруу найрагч монгол хүний нүдээр хаяагаараа үзэгдлийг харж энгийн атлаа ховор содон дүрслэлийг олжээ. Гоо сайхны ургацын төв нь болсон “Монгол охидын хүзүү шиг” хэмээх дүрслэл нь уншигчдын сэтгэлд дам сэрэл үүсгэж, монгол орны үрийн уур амьсгалын сайхан ба монгол охидын ажилч цэвэрхний тухай холбон бодолтын яруу эгшиглэнг бэлэглэж байнам. Энэхүү бадаг нь хэн болгон биччихмээр хэлбэр санагдах атлаа хэн болгон бичиж үл чаддаг содон бадгийн нэг жишээ ч болж болно. Учир нь иймэрхүү мөр шадууд бол хэн бүхний сэтгэлийг хөдөлгөн, гоо хүртээмжээрээ хөдлөн дагуулж чадах эш элементүүдийг нарийлаг нямбай бясалгалаар цогцолсон байдаг болохоор хүмүүсийн сэтгэл туйлын байгальлигаар хөтлөгдөж урлагийн дотоод ертөнцөд нь жуулчилдаг. Тийнхүү хялбар хэмээх өргөдөлийг ч олдог билээ. Яруу найрагч энэхүү дөрвөн шадаа залгаж:

“Зөөлөн амьсгааг нь дагалдан

Ягаан алчуур чичиргэнэж

Зүйн сайхан ичингүйрэл нь

Гэгээ татсаар ирнэ” хэмээн дүрслэлийн цовоо содон мөрүүдээс төрхжилийн цэцэн шадад орлоо. Ингэснээр түрүүчийн дөрвөн шадын ид чансааг улам нэмэгдүүлж урлагийн уур амьсгал, гоо таашаалын тэлэх хүчнийг нягт ахиулжээ. Гэхдээ энэхүү найман мөр нь “Үүр хаяарч байлаа” хэмээх шүлгийн бүхий л цогцтойгоо ямар харьцаа холбоотой байж, ямархан үйлдэл гаргаж байгаа тухай доор ярих тул энд нуршихгүй. Мөн ч энэхүү найман шүлгийн “Ямар сайхан аялгуу вэ” хэмээх шүлэгт: “Өнөө л сайхан аялгуу/алсын алсаас/ өрлөг мөнгөн сэлэм шиг/хангинаж ирсэн юм” гэсэн элмэг дүрслэл ба “Урьд нь би цэрэг байлаа/улаан цусаараа/ унасан нутгийнхаа цэцгийг усалж явлаа” гэсэн учирлан өгүүлэх ба төрхжүүлэхийг ус цас шиг уялдуулсан мөрүүд, тэрчлэн “Цагаан үс” гэх шүлгийн “Гялбаан цахиллаа”,

“Од суварлаа”, “Зам цагаарлаа”, “Үнэн хайртай сэтгэл/гадагшаа урслаа” гэх зэрэг цагаан үсний тухай төрхжүүлүүдийн яруу сайхны амжилтыг эрхэм уншигчид минь өөрөө сэтгэн тунгаах ажаамуу.

Дараад нь дүр дүрслэл, төрхжил ба цогцын эсгэмжийн органик харимхай чанарын тухайн ажиглая. Дүр төрхжил, дүрслэл нь цогцын эсгэмждээ унь ханын үйлдэл үзүүлж, бүхий л цогцоо бүрэн бүтэн болгодог нь яруу найргийн байнгын журам. Яруу найрагчид дүр дүрслэл, учирлал, төрөгжил зэргээр бүхий л цогцынхоо уурамьсгалыг тохируулж, талцыг нь уян хатан чанартай болгож, сэтгэлгээ, айзмаа өнгө будагтай болгодог. Артай найрагчийн эдгээр шүлэг нь энэхүү жамд суурилж, дотоод дүр дүрслэл, санаа төрхжилийг бүхий л цогц лугаа нарийн нямбай холбогдуулсан төдийгүй дүр дүрслэл, санаа төрхжилийг биеэ дааж нэг зүйлийн гоо сайхны уур амьсгал хүртэж чадахуйц мөртөө цогцын эсгэмжтэйгээ уялдаа босголцон сэрэгдэл өгч чадах харимхай урлалыг ч цогцлоож чадсанаараа гойд гайхамшигтай болжээ. Энэ нь даруй дотоод бүтцийн сэм үсрэлтийг уран нарийн тохируулсан ур мэргэшил билээ. Доор “Үүр хаяарч байлаа” хэмээх шүлгээр жишээ болгон энэ тухай ажиглаж үзье. Шүлэг эхлэнгүүт: “Үүр хаяарч байлаа/шөнө зүүн талаасаа өргөж/ сүрэг нэг нэгээрээ зугтана/ шувуу хааяа хол жиргэхэд/ сүү амтагдана” гэсэн төрхжилийн бадаг буй. Энэ бадагт хөдөө нутгийн үүрийг дэлгэнгүй үзэгдлээс нь төрхжүүлэн нэгэн ахуйг цогцлоосон байхад “Үүр хаяарч байлаа” хэмээх дан давталтын дараа дэгтэй жишээлж өнгөрсөн “Морины совоо тоос шиг...” гэх дүрслэлээс төрхжил зүг шилжсэн нэгэн хэсэг гарна. Энэхүү хэсэг нь төрөлх монгол орныхоо хүн байгаль, аж амьдрал, хайр дурлалын гоо сайхны аль олон сураг дуулианыг үүсгэн байхад мөнхүү “Үүр хаяарч байлаа” гэх зааг холбоосоор “Урьд шөнө/ хар дарлаа/ унтаагаараа арвин уйллаа/ миний нутгийн сайхан үүр/ мэдсэн юм шиг намайг дуудлаа” гэсэн найман мөрийг гаргаж, шүлгийн уур амьсгалыг хувиргахтай зэрэг санааны дусалд сэм үсрэлтээр хол шилжиж, сэрэгдлийн зай улам ихэслээ.

Цогцын эсгэмжийн хувьд “Миний нутгийн сайхан үүр/ мэдсэн юм шиг намайг дуудлаа” бээр “Шөнө зүүн талаасаа үргэх”-ийг нууцгайхан хугачлан авч, нарийлаг сүлжээсийн эмх дэглэмийг байршуулжээ. Дараачийн хэсэгт нь “Хөдөө нутгийн хүү/ Хөххот минь сарь л даа/ одон дотор булгисан онгон сааралдаа оч л доо/ одоогоороо яв л даа!” гэж яруу найрагч бичжээ. “Хөдөөгийн хүү/ Хөххот минь сарь л даа” гэх хоёр мөрөөр дээрх хэсгүүдтэй соронзон холбоос болж цогцын эсгэмжийн сүвэгчийг үл алдсанаар дүр төрхийн харимхай чанар гялсан тодорч, сэм үсрэлтээр цогцын талцыг бүрдүүлжээ. Ондoo дархан бол энд жолоогоо татсан ч болох байлаа. Гэвч шүлэгчээс “Олон юм эхлэх нь ээ/ олон юм эхлэхсэн оройтоогүй биз!?!/ Үүр хаяарч байлаа” гэх мөрөөр бүхий л цогцын нарийлаг эсгэмжийн сүлжээсийг ончтой зангидсан байна. Ингэснээр бүхий л цогц нягт бүрэн бүтэн болж уран санааны систем улам ч эмх цэгцтэй, өнгө гялбаатай болсныг онцлон өгүүлэлтэй.

“Дэлхий дахины сонгодог уран зохиолын түүхээс авч үзвэл аливаа зохиолч уран бүтээлдээ аль нэг юмс үзэгдэл, үйлдэл, өнгө чанар бэлгэ тэмдгийг шүтэн бичих нь түгээмэл байдаг” (Мөнгөнхөлөг, 1998: 25). Үүний нэг улбаа бол монгол ахутай холбоотой сэдэвтэй зохиол бүтээлийг туурвихдаа, зохиолч аль нэг содон зүйлийг сонгон авч бичдэг нь санамсаргүй хэрэг биш юм. Монгол ахуй, байгаль цаг улирлын өвөрмөц сонин дүрслэл, зураглалтай холбогдуулж, гүн ухааны шинжтэй санаа бодлыг илэрхийлсэн шүлгүүдийг, түүний дундаас эх орныхоо аялгуу бүрийг шингээсэн шүлгүүд Артайн яруу найрагт өргөн дэлгэр ажээ.

Залгаад бид шүлгийн олон зүйлийн урлагийн хэв намбыг нэгтгэн цогцын эсгэмж ба дотоод бүтцийг хэрхэн органик нарийн болгсныг шинжилье. Ер нь онол шүүмжийхний ялгал судлалаар бол яруу найрагт уянгын шүлэг, хүүрнэл шүлэг “Уянгын найраглал, хүүрнэл найраглал” нь тус тусынхаа төрөл жанрт ангилагдах мөртөө ахуйч үзлийн шүлэг ба бэлгэдэл үзлийн шүлгийн зааг зөрөөг нь нэн ч их билээ. Шүлэгч Артай “Ямар сайхан аялгуу вэ?” гэх шүлэгт харин ч уянгын шүлэг ба найраглалын урлагийн намбыг нэгтгэн ахуй ч бодьгал шинж ба санааны бэлгэдэл шинжийг ус цас шиг нийцүүлж, төрхжил, учирлал, дүр дүрслэлийн дотоод бүтцийг нарийлаг тохируулан бүхий л схемээ гайхамшигтай болгосон байнам. Тус шүлгийн эхлэл төгсгөл бүрд “Ямар сайхан аялгуу бэ? Хаанаас над руу ирнэ вэ!” гэсэн хашилттай бөгөөд хэсэг болгоны хооронд “Ямар сайхан аялгуу вэ?” гэсэн дан давталттай шүлгийн хүүрнэл шинжээс нь ажиглавал эхний хэсэгт шөнө шүлэг бичиж ядрахад нь “Хосгүй сайхан аялгуу”, “Хулан шиг цахилж ирдэг” нэгэн учир, хоёрдугаар хэсэгт нь хонь хариулж байхад нь “өнөө л сайхан аялгуу/ алсын алсаас өрлөг мөнгөн сэлэм шиг хангинаж ирсэн учир”, гуравдугаарт нь дайнд эндэж унахад нь “Нэг л сайхан аялгуу нисэн ирсний улмаас би үхээгүй учир бичигджээ. Бэлгэдлийн хувьд дүрслэлүүд нь тулгуурлах үйлдэл үзүүлж байна. Жишээлэхэд “Хулан шиг цахилж ирэх” нь ядрал тайлах хүсэмжлэлд яв цав зохицох бөгөөд “Уйтгараа ноцоогоод”, “Шөнийг шатаах”-тай уялдан нэг зүйлийн бэлгэдэл болсон байхад, “Өрлөг мөнгөн сэлэм шиг хангинаж ирсэн” нь “Хулгана арвиджээ”, “Тун гантай жил болох нь”-ээс шууд шалтгаантай байж, “Миний зовхиноос дүүжигнэсэн тэр нулимс газар унасангүй юм”. Дайсанд жадлагдан унаж “Баяртай, эх орон минь гэж хэлж амжих” дуу “Эх түүх ч юм шиг, ирээдүй ч юм шиг нэг л сайхан аялгуу зүрхнээс ургаж байгаа ч юм шиг зүйтэй төрсөн жимс хуартайгаа эрвээхэй дагаж байсан зүлэгнээс минь ундарч байгаа ч юм шиг ниссээр, ниссээр над дээр ирлээ би өгсөнгүй” гэх мөр шадуудад хүүрнэл ба дүрслэл цай сүү шиг идээшин “Ниссээр, ниссээр” ирэх төрхжил ба үүнээс болж сая “Би өгсөнгүй” гэх учирлалтай харимхай чанартай холбоос буй болж, нэг зүйлийн бэлгэдэл ахуйг цогцолжээ. Энэхүү бэлгэдэл ахуйд “Баяртай, эх орон минь гэж хэлж амжлаа” хэмээх учирлал ба хүүрнэл болон дүрслэлийн уялдал (Дээр жишээлсэн хүүрнэл дүрслэл) гантиг суурь нь болж буй. Энэхүү гурван бэлгэдэл ахуйг нэг цогц болгосон хэлхээс нь даруй “Сайхан аялгуу” бөгөөд үүнээ “Ямар сайхан аялгуу вэ?/ Хаанаас надад ирнэ вэ?” гэдэг энгийн учирлалаар гүн ухаалаг бэлгэдэл болгож чадсан нь даруй яруу найрагчийн ховор нандин авьяас эрдэм билээ.

Яруу найрагчид хүний оюуны сэтгэмжил гэрэл гэгээ хайрлах өнө мөнхийн шидийг бясалгадаг сан. Дээр би яруу найрагч Артайн шинэ бүтээл “Сэтгэлийн найман нөхөөс”-өөс хэдийг сонгон өнөө үеийн сонгодог шүлгийг цаг даруйд нь уншигч олноо танилцуулж, хамтаар амьдрахыг хичээлээ. Одоогийн шинжээс үзвэл, яруу найраг минь алхац нь удааширч, төдийлөн өрнүүн далайцтай биш болж, зонгонгуйрч буй нь үнэн. Гэхэд харьцуулгат найрагчид мөнхүү уяагүй шаргуу хөдөлмөрөөр яруу найргаа өргөмжилж байх төдийгүй шилдэг содон бүтээл гарсаар байгаагийн төлөөлөгч нэгэн жишээ энэ байна.

ДҮГНЭЛТ

Хүн төрөлхтөн эртнээс нааш бүтээн бий болгосон оюуны соёлын нэг чухал бүрэлдэхүүн хэсэг нь уран зохиол юм. Үүнд “тухайн үндэстнүүдийн уламжлалт

аж төрөх ёс, зан заншил, туулж өнгөрүүлсэн түүх, амьдрах ухаан, нийгмийн харилцааны халагдал солигдол, түүнийг дагасан хүний хөгжлийн явц хандлага болон угсаатны зүй хэл соёл, уран сайхны сэтгэлгээний уламжлалт онцлог хадгалагдаж, шинэчлэгдэн баяжиж үндэснийхээ өвөрмөц хэв шинжийг тодотгож байдаг ерөнхий зүй тогтол бий” (Галбаатар, 2009: 10).

Орчлон хорвоогийн мөн чанар, агуулгыг өөртөө шингээн, дүрслэн илэрхийлж чадах, цорын ганц төлөөлөл нь яруу найраг юм. Яруу найраг нь, үлгэр домог, зөн билиг, хайр дурлал, гүн ухаан, ид шид, гайхал эргэлзээ, айдас хүйдэс, энэ хорвоогийн байж болох бүхний хувилбар, үгийн тоглоом, үгийн шид, үгийн боломжит үйлчилгээ билээ.

Үг, бодрол бүрхэн гэрэл, долгион бөгөөд бодролын эрчим, цөм нь дүрслэл юм. Дүрслэл нь үгээр илрэх долгионы давтамжтай. Бодролын долгион нь эрчим, эрчим нь эд эс, эд эс нь эгшиг авиа, эгшиг авиа нь хэл яриа, хэл яриа нь хүсэл мөрөөдөл, хүсэл мөрөөдлөөс, амьдралыг захиалагч цөм болон гадагшилж, бодит ертөнцийг буй болгодог “Үг” төрнө. Үг бүхэн утгатай билээ.

Ашигласан материал

Артайн шүлгийн түүвэр (2007). *Өвөр монголын одоо үеийн уран зохиолын сан*. Улаанбаатар: Бемби сан.

Галбаатар, Д. (2009). *Уран зохиолын онолын удиртгал хичээлээр оюутанд тусламж* / Д. Галбаатар, Р. Бигэрмаа, С. Дашдэжид. Улаанбаатар: Бит пресс.

Мөнх, Ц. (1990). *Б. Явуухулангийн яруу найргийн туршилага*. Улаанбаатар.

Мөнгөнхөлөг, Х. (1998). *Өчүүхэн дэвтэр*. Улаанбаатар.

Энхбаяр, С. (2000). *Утга зохиолын онол туурвилзүй*. Улаанбаатар.

References

A Collection of Artay's Poems (2007). *Inner Mongolian contemporary literature fund*. Ulaanbaatar: Bambi Foundation (in Mongolian).

Galbaatar, D. (2009). *Help for students in the introductory course of literary theory* / D. Galbaatar, R. Bigermaa, S. In Dashdeji. Ulaanbaatar: Bit Press (in Mongolian).

Munh, Ts. (1990). *B. Yavuukhulan's poetic experience*. Ulaanbaatar (in Mongolian).

Munganholog, H. (1998). *Small notebook*. Ulaanbaatar (in Mongolian).

Enkhbayar, S. (2000). *Literary theory and creativity*. Ulaanbaatar (in Mongolian).